



## МОРИН ХУУРЫН СУРГАЛТААР СУРАГЧДАД МОНГОЛ УЛАМЖЛАЛТ ЗАН ЗАНШЛЫГ ТАНИУЛАХ ДУУНЫ ТҮҮВЭР СУДАЛГАА

<sup>а</sup>Аюуш Оюунтунгалаг, <sup>б</sup>Төмөрбагана Хонгор  
<sup>а</sup>МУБИС-Багшийн сургууль, дэд профессор, доктор  
<sup>б</sup>БНХАУ, ӨМӨЗО, магистр

Холбоо барих зохиогч: [oyuntungalaga@msue.edu.mn](mailto:oyuntungalaga@msue.edu.mn)

Хүлээн авсан: 2023.11.20

Хянагдсан: 2023.12.01

Зөвшөөрсөн: 2023.12.20

### Хураангуй

Морин хуур бол монгол үндэстний онцлог шинж бүхий өнө удаан жилийн түүхтэй, уламжлалт хөгжмийн зүйл бөгөөд нүүдлийн соёл ба малжих соёлтой хамгаас идээшиж нийцсэн, үе үеийн хөгжимчдийн тасралтгүй өөрчлөлт шинэчлэлээр дамжин, дэлхийд алдаршсан хөгжим болсон. Үүний зэрэгцээ морин хуурын түүх соёлын агуулга ба гарал үүсэл, хэлбэр дүрсийн өөрчлөлт шинэчлэлт, татлага дарлагын арга барил тогтворжиж, сургалтын арга барилын талаарх судлал нэлээд гүнзгийрч, морин хуур судлал дэлхийн хэмжээний судлал болсон. Гэвч морин хуур судлал болон заах арга зүйн судалгаа нь салангид нэгдэлгүй, мөн уламжлалт ёс заншлыг заахын ач холбогдол, боломжийг ашиглахгүй орхигдуулж байгаа нь анхаарал татаж байна. Энэхүү хөгжмийг хүүхдэд заахдаа үндэстнийхээ уламжлалт зан заншилтай уялдуулан, морин хуур хөгжмийн түүх соёлын агуулгыг таниулбал зохино. Мөн морин хуураар тоглож сурах хөгжмийн ая, дууг сонгохдоо түүх, уламжлалт ёс заншлыг өгүүлсэн дууг судлан, түүвэрлэн илрүүлж, сургалтын хөтөлбөрт оруулан заах нь зүйтэй юм.

### Түлхүүр үг

Морин хуур заах арга зүй, түүх, соёл, зан үйл, ардын дуу хөгжим

### Удиртгал

Нүүдлийн соёл болон хялгасан хөгжимтэй монгол үндэстэн бол өнө удаан түүхтэй, өнөр баялаг соёл боловсролтой үндэстэн. Монголчуудын бий болгосон хөгжмийн зэмсэг нүүдэлчин амьдралдаа зохицож, таван хошуу мал сүргийнхээ арьс, үсийг чадварлаг ашигласнаараа онцлогтой.

Монголчууд морийг онцгой дээдэлдэг. Монголчууд морь малаа маллахынхаа

зэрэгцээгээр шившлэг дуудлага, ерөөл магтаал, үлгэр тууль, дуу хөгжим, бүжиг, туурвин бүтээх зэргийн уран сайхны мэдрэмж, чадварыг үлэмж гүйцэд эзэмшсэн байдаг.

Одоогийн байдлаар морин хуур хөгжмийн Өвөр Монгол дахь судлалын хувьд авч үзвэл, Тулгуур, Хурц нар “Монголын нууц товчоон дахь морин соёлын судлал”, Бүрэн “Монгол үндэстний хялгасан хөгжмийн тухай дахинтаа өгүүлэх нь”, Тэнгис “Морин хуурын орд нумын татлагын сүвэгчлэл”, Жан Жин Шен “Морин хуурын зам мөр”, Ван Ши Нүвегийн “Ашид дуурсах морин хуурын эгшиг-Морин хуурч Сандүүрэнг тэмдэглэв”, Бай Даваагийн найруулсан “Морин хуур хөгжимдөх арга барил”, Жу Жин Бүгийн найруулсан “Морин хуур хөгжимдөх арга барил” хэмээх зохиол бүтээл голчлон судалгаануудад иш татагдаж, тэмдэглэгдэж байна.

Ардын дуу хуур, түүний зан заншлын Өвөр Монгол дахь судлалын хувьд нэрлэвэл, Төмөрбагана “Хорчин ардын дууны түүх соёлын тайламж” мөн “Хорчингуудын (дуу барих) ёсон”, Зан Хөн Мин, Зан Най Фү “(Нуунзаяа)-ийн үүсэл гарал”, Хүрэлшэ, Сэргэлэн нарын “Хорчин ардын дууны баатрын домог намтар”, Жин Түн “Дөрвөд ардын дуу (Нуунзаяа)-ийн онцлог шинжийн тухай дөхөм шинжлэл”, “Онол ажиглалт”, Оюунгэрэл “Урлагийн дүр болон түүхт хүн, ардын дуу (Ши Шү мэйрэн) буюу түүхт хүн Чи Шиүгийн харьцааг задлах нь”, Өлзийсаны эмхэтгэн найруулсан “Хорчин ардын дуу” зэрэг ном бүтээлд ардын дуу, түүний соёлын өгүүлэмжийг судалсан байна.

Морин хуурын сургалтын явцад уг хөгжмийн түүх соёлын агуулга, монголчуудын уламжлалт ёс, зан заншлыг таниулж ойлгуулах арга зүйн талаар судалгаа, судалгааны бүтээл хомс байгаа тул судлах, турших нь чухал байна.

## Арга зүй

Уг судалгааг хийхдээ Хорчин зүүн гарын дунд хошууны Бага сургуулийн тавдугаар оны дээд хугацааны дууны хичээлийн хөтөлбөр, уг хөтөлбөр дэх морин хуурын гоцлол хөгжим, аяз, дууны санг судлав. Мөн Хорчин зүүн гарын дунд хошууны Багачуудын ордны морин хуурын сургалт, түүнд хамрагдсан сурагчид, сургалтын хөтөлбөр дэх дууны урын сан зэргийг судалж, сурагчдад морин хуур хөгжим заахын хамт уламжлалт соёл, зан заншлыг мэдлэгийг хэрхэн эзэмшүүлж болохыг туршин зааж, судалгаа хийлээ.

Мөн монгол ардын дууг цуглуулан, дуун дахь үндэстний буюу орон нутгийн соёл түүхийн хамаатай зан заншил, ёс учрыг гүнзгийрүүлэн судалсан. Морин хууртай холбоо бүхий домог үлгэр, хууч яриаг эмхэтгэн цуглуулав.

Түүхийн судалгааны аргаар морин хуурын түүх соёлд холбогдсон зан үйл, морин хуурын гарал үүсэл, хэлбэр дүрсийн хувирал хөгжлийг тодрууллаа.

Сурвалж судлалын аргаар морин соёл болон морин хуурын монгол үндэстний уламжлалт соёл, зан заншил дахь байр суурь, нүүдлийн соёл ба малжих амьдралын монгол соёл урлагт үзүүлсэн нөлөөг гүнзгийрүүлэн судлав. Сургалт, туршилтын үйл ажиллагаанд суурилан онолыг практиктай уялдуулж, морин хуурын сургалтаар дамжуулан сурагчдад монгол соёл, зан заншлыг уламжлуулах талаар туршилт явууллаа.

## Судалгааны үр дүн

Судалгаа, сургалт туршилтын үр дүнд “Морин хуурын сургалтын/хичээлийн хөтөлбөр”-ийг судаллаа. Зорилгоо хэрэгжүүлэхээр сургалт хичээлийг зааж, туршилт хийлээ. Монгол ардын дуу, түүний түүхэн утга агуулга, өгүүлж буй уламжлалт зан заншлыг илрүүлэв. Эдгээрээс морин хуур тоглон сурахад тохиромжтой, түүх, уламжлалт зан заншлыг өгүүлсэн дууны жагсаалт гарган, зан заншлаар нь ангилан төрөлжүүллээ. Сонгосон дууг сургалтад нэвтрүүлж, морин хуураар тоглож сургалаа.

## Судалгаа туршилтын талаар товч өгүүлбэл:

1. Морин хуурын хөгжим “Гаадаа мэйрэн”-д илэрсэн үндэсний зан заншлыг сурагчдад зааж ойлгуулсан туршилт хичээлийн явцаас товч өгүүлбэл, Хичээлийн агуулга: Бага сургуулийн тавдугаар оны дээд хугацааны дууны хичээлийн хөтөлбөр дэх морин хуурын гоцлол хөгжим “Гаадаа мэйрэн”-ий сонирхомж Хичээл сургалтын үзэл баримтлал:

- Морин хуурын гоцлол хөгжим “Гаадаа мэйрэн”-г сонсож, дууны гол утга санааг ойлгоно.
- Морин хуур хөгжмийг танин мэдэж, морин хуурын өндөр богино сул чанга ба хүнгэнэм, хангинам аялгуу хөгийг ялган таньж, хөгжмийн бүтээл дэх чухал санааг ялган танина.
- Шин Ху Гуаны зохион бүтээсэн найрал хөгжим “Гаадаа мэйрэн” ба дуучин Тэнгэрийн дуулсан “Гаадаа мэйрэн” гэх дууг сонсож, сурагчдыг удирдан дууны бүтээл ба хөгжмийн бүтээлийн адил бус чиглэлээс “Гаадаа мэйрэн”-ий түүхэн учир утгыг ойлгуулж, сурагчдын үндэсний баатраа хүндэтгэж хайрлах, амь ахуйгаа дээдлэх үзэл ухамсрыг хөгжөөнө.
- Энэхүү дуу аялгуугаар сурагчдад монгол үндэстний орон нутгийн түүх соёлын талаарх мэдлэгийг эзэмшүүлнэ.

Хичээл сургалтын зорилго зорилт: Дууны болон хөгжмийн бүтээл дэх уран сайхны сэтгэлгээний онцлог, түүх, уламжлалт зан заншлыг илрүүлэн таниулна.

Туршилт хичээлийн үр дүн: Морин хуурын сургалтад хамрагдахаар ирсэн сурагчдаас хичээлийн өмнө монголчуудын морийг хүндэтгэн дээдэлдэг морин соёлыг мэдэх эсэх, морин хуур хөгжим болон чавхдасыг юугаар хийдэг гэх зэрэг морин хуур хөгжмийн үүсэл гарал, бүтэц, онцлогийн талаарх асуултуудыг асууж тодруулсан. Асуулгаар сурагчдын 68 хувь нь энэ талаар огт мэдэхгүй байгааг тогтоосон юм. 2 жилийн сургалтын дараа дахин асуулга авахад энэ хувь 5 хувь болж буурч, 95 хувь нь морин хуур хөгжим болон уламжлалт зан заншлын талаар гүнзгий мэдлэгтэй болсон юм. Хичээл сургалтын дүнд сурагчдын морин хуур хөгжмийг эзэмшсэн байдал 98 хувьтай үнэлэгдлээ.

2. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Монгол дунд сургууль болон Багачуудын ордны Морин хуурын сургалтын хөтөлбөрт монгол ардын уламжлалт ёс, түүх, зан заншлыг өгүүлсэн дууг оруулж заахын тулд ардын дууг судаллаа.

Морин хуурын хичээл сургалтад сонгогдсон дуунаас жишээлэн авч үзвэл, Өвөр Монголын зүүн хэсэг оронд өргөнөөр дэлгэрсэн ардын дуу “Нуунзаяа”/Нонзаяа, түүний түүхэн агуулгаас өгүүлбэл:

“Луухын голын хөвөөн дээр  
 Ногтоо чирсэн морь оо  
 Номхон зантай Нуунзаяа  
 Нутгаасаа хол заяажээ.  
 Хайчин голын хөвөөн дээр  
 Хазаараа чирсэн морь оо  
 Хайрхан зантай Нуунзаяа  
 Хязгаараасаа хол заяажээ”

хэмээн дуулдаг. Дуунд нутгаасаа салж ядаж байгаа Нуунзаяа бүсгүйн сэтгэлийг ногтоо чирэн нутаг зүгээ газарласан мориор зүйрлэсэн нь сонсогчийн сэтгэлийн угийг хөндсөнөөс ихээхэн амжилт олж тархсан ардын дуу. 1946 оны үеэр Ан Бүвэ багш Өвөр Монголын зүүн хэсэг оронд хувьсгал хийхдээ тус дууг эмхэтгэн цуглуулж “Зүүн монголын ардын дууны сонгомол”-доо түүвэрлэснээс “Нуунзаяа” нь Дундад улсад алдаршаад, одоо “Дундад улсын 56 үндэстний ардын дуу”-ны нэгд багтан, Монгол үндэстний төлөөлөгч ардын дуу болжээ. Тус дууны аяыг сурагчдад морин хуураар заахдаа хоёр зүйлийг чухалчилна. Үүнд, нэгд. Нуунзаяагийн төрсөн нутгийн тухай, хоёрт. Малжих соёл буюу тариалах амьдрал, түүний зан заншлын тухай мэдүүлэх юм. “Нуунзаяа” дуунд:

Далантай тариа гэж тарихгүй  
 Дуува ногоо гэж идэхгүй  
 Давшин давшин шимэхэд  
 Мөөмний сүүний амт аа  
 Уйцайтай ногоо гэж тарихгүй  
 Шууваа ногоо гэж идэхгүй  
 Шимэн шимэн сороход  
 Мөөмний сүүний амт аа гэх зэргээр дуулдаг.

3. Судалгааны дүнд монгол ардын 571 дууны өгүүлэмж буюу түүх, уламжлалт зан заншлыг судаллаа. Ингээд морин хуур хөгжмөөр хөгжимдөхөд тохиромжтой, сурагчдын нас сэтгэхүйд тохирсон, утга уянга сайтай, үг хэллэг ойлгомжтой, тодорхой ёс, зан үйлийг өгүүлсэн өгүүлэмж сайтай, хүмүүжлийн ач холбогдолтой доорх нэр бүхий монгол ардын 61 дууг сонгон, угсаатан ястнаар мөн сэдэв агуулга, зан заншлаар нь дараах байдлаар ангилан төрөлжүүлээ.

Хүснэгт 1. Монгол ардын дууны судалгаа

№	Судалсан дуу	
1.	Монгол ардын дуу	88
2.	Баруун монгол ардын дуу	75
3.	Зүүн монгол ардын дуу	46
4.	Буриад ардын дуу	35
5.	Өвөр монгол ардын дуу	327
<b>Нийт судалсан дуу</b>		<b>571</b>

Хүснэгт 2. Морин хуурын сургалтад оруулсан дуу, түүний ангилал

Өгүүлэх ёс, зан үйл	Үндэстэн, угсаатан, ястан				
	Монгол	Хорчин	Торгууд	Ойрад	Буриад
Ээж ааваа дээдлэх	Болго, Гөрөөс, Ба Эве Лин, Аггт толгой, Ар дэлхий, Алтан сүмбэр уул				Аав ээжийн сургаал
Нутаг усаа дээдлэх	Баянзүрх уулын магтаал, Ба Эве Лин, Галуу, Ен Лан, Өнө өргөн Алша				
Уул ус, галын тахилга, зан үйл	Дөрвөн булгийн тунгалаг, Гал тахиx дуу				
Түүх, хувьсгал, цэрэг	Өвөр Монголын хувьсгал, Чойжог зар	Цахар найман хошуу			
Баагарлаг үйлс, үйлстэн	Ший Шуу мэйрэн, Доо Нин Ге, Хай Лүн, Өргөлтэй	Бинг ван, Сэн ван, Тогтох баатар, Гаадаа мэйрэн			
Ёс заншил дээдлэх	Ван Ший Шен, Юндэн Гөөгөө, Цоорын магтаал, Төвийг эрхэмлэх сургууль, Өнчин өрөөсний дуу - Хай Ли Хай Дан	Эве шиян, Мөчүрэй,	Тэнгэрийн наагуур	Сумъяагийн цэцэг	Хянгaн голын бялзуухай
Морийг дээдлэх	Үүлэн хөх морь, Хөгшин хоохон				
Шашин шүтлэг	Сахиулсан залах дуу, Баруун Бээжин, Хүрээ сүмийн магтаал	Дүри удган			
Үндэсний гэр, хувцас	Монгол хувцас, Эсгий гэрийн ерөөлийн дуу				
Наадам, овооны наадам	Бөг тавих				
Хайр сэтгэл	Бай хүү гээг, Хирүү	Бөмбөөрэй			
Хурим найр	Дөрвөн далай, Мелима,	Барын хүчин			
Бэрийн дуу	Ашима, Нуунзаая, Ен Лан, Навч гүнж, Оюунзандан, Мелима	Ший Лөө, Ший Ши Лин, Жан мөрний ус, Бөмбөөрэй, Богд эзэн Чингис, Төрийн дуу			

## ДУГНЭЛТ

Морин хуур хөгжим алдаршихын хамт олон хүн морин хуур сурч, хөгжимчин болох замаар замнах болон урлаг, гоо сайхан ба үндэстний түүх соёл, зан заншлаа ойлгож мэдэх суурь хүмүүжилтэй болж байна. Бүрэн бус бүртгэлээр “Дэлхий дээр 6 түм гаруй хүн морин хуур сурч буй” ажээ. Бидний явуулсан сургалт, туршилт нь морин хуурын сургалтыг үндэстний түүх соёл буюу зан заншилтай холбон заах нь үр ашигтай, сурагчдыг уламжлалт зан үйл, соёлын тухай мэдлэгтэй, урлаг, гоо сайхны суурь хүмүүжилтэй болгож болохыг харуулж байна. Үндэстний соёл бол газар орон буюу үндэстний оршин амьдрах үзэл бодол, ухамсрын суурь байдаг.

## НОМ ЗҮЙ


1. Алтангэрэл. (2013) “Монголчуудын наран шүтлэг” Ляонины Үндэстний хэвлэлийн хороо.
2. Бай Буу Чиуван. (1995) “Монголжин ардын дуу” (1-3 дугаар боть) Нүүдлийн соёл Багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.
3. Бай Даваа. (1983) “Морин хуур хөгжимдөх арга барил” Хөн Тү хэвлэлийн хороо.
4. Бадраа Ж. (2008) “Монгол ардын хөгжим” Нүүдлийн соёл Ардын хэвлэлийн хороо.
5. Баяуд Хөхмөчир. (2009) “Адуун соёлын товчоон” Нүүдлийн соёл Ардын хэвлэлийн хороо.
6. Жак Уэтерфорд. (2017) “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Чингис хаан” Нүүдлийн соёл Ардын хэвлэлийн хороо.
7. Жу Жин Бу. (2017) “Морин хуур хөгжимдөх арга барил” Нүүдлийн соёл Ардын хэвлэлийн хороо.
8. Лувсанчойдон. (1981) “Монголын зан аалийн ойлбор” Нүүдлийн соёл Ардын хэвлэлийн хороо.
9. Мөнгөнцэцэг, Чин Шан нар. (2008) “Зан үйл өв соёл” (Аравдугаар хэсэг - цээр) Нүүдлийн соёл сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
10. Оюунтунгалаг А., Өнөрбаян Ц. нар. (2020) “Өнөөгийн Монгол угсаатан” Улаанбаатар.
11. Өлзийсан. (2012) “Хорчин ардын дуу” (дээд, дунд, доод) Нүүдлийн соёл Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
12. Рэнцэндорж, Донровжамц. (1979) “Монгол ардын мянган дуу” (1-5 эмхэтгэл) Нүүдлийн соёл Ардын хэвлэлийн хороо.
13. Сэргэлэн. (2013) “Морин хуурын шилжүүлсэн хөгжмийн түүвэр” Нүүдлийн соёл ардын хэвлэлийн хороо.
14. Улалж. (2021) “Монгол үндэстний дуу хөгжмийн түүх” Юань Фэн хэвлэлийн хороо.
15. П.Хорлоо. (1989) “Монгол ардын дууны яруу найраг” Нүүдлийн соёл Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
16. Хөгжилт. (2006) “Монгол үндэстний дуу хөгжмийн түүх” Ляонины үндэстний хэвлэлийн хороо.
17. Хүрэлшэ. (2017) “Хорчин ардын дууны баатрын домог намтар” Нүүдлийн соёл Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

## **STUDY ON A SAMPLING OF SONGS TO INTRODUCE STUDENTS TO MONGOLIAN TRADITIONAL CUSTOMS THROUGH MORIN KHUUR TRAINING**

<sup>a</sup>A.Oyuntungalag, <sup>b</sup>HONGGEER

<sup>a</sup>Ph.D., Associate professor, Teachers School, MNUE

<sup>b</sup>China, Inner Mongolia, master

Corresponding author: oyuntungalaga@msue.edu.mn 

### **Abstract**

The Morin Khuur (horse fiddle), a traditional musical instrument steeped in history, is ideally suited to nomadic life and culture. Evolving over generations under the guidance of musicians and masters, it has attained global acclaim. This study examines the stabilized content and origin of the instrument's history and culture, as well as the evolution of its form and stringing methods. Concurrently, it explores the deepening study of teaching methodologies, elevating Morin Khuur studies to a world-class pursuit. However, the separation and lack of integration between its studies and teaching methods are deemed inappropriate, leading to the neglect of the importance and opportunities associated with teaching traditional customs. When instructing children in Morin Khuur music, it is appropriate to incorporate historical and cultural content aligned with national traditions. Furthermore, the selection of music tunes and songs for teaching should prioritize pieces that narrate stories and uphold traditional customs, enriching the curriculum. By bridging the gap between Morin Khuur studies and traditional customs, this research aims to enhance teaching methods and foster a deeper appreciation for the cultural heritage inherent in traditional music, particularly in children's education.

### **Keywords**

Teaching methodology of Morin khuur, history, culture, traditional custom, traditional song and music

---